



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/840

Булган сум

Сумын Засаг дарга,  
тосгоны Захирагч нарын 2023 оны  
“Хамтран ажиллах гэрээ”-г дүгнэсэн тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.5, 59 дүгээр зүйлийн 59.1.8, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргатай сумын Засаг дарга нар, тосгоны Захирагчийн 2023 онд “Хамтран ажиллах гэрээ”-г дүгнэсэн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.Хамтран ажиллах гэрээний үнэлгээг үндэслэн холбогдох журмын дагуу урамшуулал олгохыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3.Хамтран ажиллах гэрээг дүгнэсэн байдалд дүн шинжилгээ хийж, 2023 оны хамтран ажиллах гэрээг оны эхнээс заалт нэг бүрээр нь хяналтад авч биелэлтийг тооцож тайлагнахыг сумын Засаг дарга нар, тосгоны Захирагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
12 дугаар сарын 18-ны өдрийн  
А/8.40 тоот захирамжийн хавсралт



**Аймгийн Засаг даргатай сумын Засаг дарга, тосгоны Захирагч нарын  
хамтран ажиллах гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ**

№	Сум, тосгоны нэрс	Үнэлгээ хувиар
1	Баян-Агт сум	90.0
2	Баяннуур сум	85.4
3	Бугат сум	89.0
4	Булган сум	90.5
5	Бүрэгхангай сум	89.0
6	Гурванбулаг сум	92.0
7	Дашинчилэн сум	89.8
8	Могод сум	93.0
9	Орхон сум	85.6
10	Рашаант сум	87.0
11	Сайхан сум	94.0
12	Сэлэнгэ сум	90.1
13	Тэшиг сум	90.8
14	Хангал сум	90.0
15	Хишиг-Өндөр сум	82.9
16	Хутаг-Өндөр сум	90.0
17	Хялганат тосгон	90.1